



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025 Х



www.ubstat.mn



Улаанбаатар хот
2025 он



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025
10 сар



АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	1
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	2
	Чингэлтэй дүүргийн өрх, хүн амын 2024 оны үндсэн үзүүлэлт	2
I	Эрүүл мэнд	4
II	Нийгмийн даатгал, халамж	7
III	Гэмт хэрэг	10
IV	Дүүргийн төсөв	12
V	Хэрэглээний үнэ	15
VI	Нийтийн аж ахуй	18
VII	Аюулгүй байдал	19
VIII	Төрийн бусад үйлчилгээ	20

ХҮСНЭГТ 1.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 I-X	2024 I-X	2025 I-X
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	1 902 ↓126	1 604 ↓15.7	1 636 ↑2.0
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	1 113 ↓89.8	997 ↓10.4	2 043 ↑104.9
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	0.2 ↓77.8	0.7 ↑250.0	0.7
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	142.6 ↑23.4	181.2 ↑27.1	224.5 ↑23.9
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	141.2 ↑28.2	184.8 ↑30.9	215.3 ↑16.5
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ =₮	3 407.1	3 413.5 ↑0.2	3 572.5 ↑4.7

ХҮСНЭГТ 2.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2024 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дүүргийн дүн	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн дундаж ам бүлийн тоо ¹	Хүн ам зүйн ачаалал ²
	36 857	133 044	3.6	56.3
1 -р хороо	855	3 560	4.2	64.7
2 -р хороо	955	3 310	3.5	65.0
3 -р хороо	1 566	5 644	3.6	61.3
4 -р хороо	1 256	4 936	3.9	56.5
5 -р хороо	1 206	4 617	3.8	56.3
6 -р хороо	2 515	9 119	3.6	63.0
7 -р хороо	1 761	5 935	3.4	53.6
8 -р хороо	916	3 160	3.4	52.1
9 -р хороо	1 504	5 310	3.5	52.9
10 -р хороо	1 946	7 295	3.7	57.2
11 -р хороо	1 208	4 337	3.6	51.0
12 -р хороо	1 554	5 592	3.6	54.1
13 -р хороо	1 732	6 466	3.7	57.0
14 -р хороо	1 526	5 492	3.6	54.6
15 -р хороо	2 041	7 552	3.7	56.8
16 -р хороо	1 959	7 515	3.8	56.9
17 -р хороо	2 154	7 645	3.5	54.9
18 -р хороо	2 010	6 566	3.3	50.8
19 -р хороо	1 919	6 718	3.5	54.2
20-р хороо	1 277	4 629	3.6	53.5
21-р хороо	1 804	6 960	3.9	56.5
22-р хороо	1 105	4 038	3.7	54.5
23 -р хороо	1 199	4 061	3.4	57.7
24 -р хороо	889	2 587	2.9	62.2

¹ Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

² Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.


IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



МЭДЭЭЛЭЛ

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрүм	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мянга	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

2025 оны эхний 10 сард 1627 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 43 (2.7%) төрөлтөөр өссөн байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2025 оны эхний 10 сард 1627 эх амаржиж, 1636 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 43 (2.7%) мэндэлсэн хүүхэд 32 (2.0%) -өөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 3.

ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2025 оны эхний 10 сард

Үзүүлэлт	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Өсөлт, бууралт 2024-2025	
				Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	1 896	1 584	1 627	43	2.7
Амьд төрсөн хүүхэд	1 902	1 604	1 636	32	2.0
Нас барсан хүн	655	682	726	44	6.5
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	19	16	18	2	12.5
1-5 настай хүүхдийн эндэгдэл	3	5	4	- 1	-20.0
Амьгүй төрөлт	12	10	10	-	-
Гэрийн төрөлт	5	8	3	- 5	-62.5
Хяналтгүй төрөлт	13	14	9	- 5	-35.7

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

ЗУРАГ 1.

АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар




2025 оны эхний 10 сард нийт 793079 үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 131425 (19.9%) өссөн бол

эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 4957 болж өмнө оны мөн үетэй харьцуулахад 1152 (18.9%) хүнээр буурчээ.

ЗУРАГ 2.

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Бэлгийн замын халдварт өвчин 246 буюу нийт халдварт өвчний 12.0 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн 10-р сард

Төрөл	2023 I-X		2024 I-X		2025 I-X		2025/2024	
	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Дүн	Хувь
Дүүргийн дүн	1 113	75.4	997	71.8	2 043	151.7	1 046	2.0*
Гепатит	15	1.0	6	1.0	11	0.8	5	83.3
Цусан суулга	126	8.5	137	9.8	68	5.0	-69	-50.4
Сальмонеллез	8	0.5	29	2.1	24	1.8	-5	-17.2
Хоолны хордлого	0	0.0	44	3.1	29	2.2	-15	-34.1
Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга	0	0.0	5	0.4	7	0.5	2	40.0
Салхин цэцэг	345	23.4	274	19.5	406	30.1	132	48.2
Менингококкт халдвар		0.0		0.0	3	0.2	3	
Гахайн хавдар	8	0.5	15	1.1	5	0.4	-10	-66.7
Улаан эсэргэнэ	48	3.3	23	1.6	41	3.0	18	78.3
Ёлом	4	0.3	8	0.6	9	0.7	1	12.5
Улаан бурхан	0	0.0	0	0.0	712	52.9	712	
Бруцеллэз	0	0.0	0	0.0		0.0	0	
Гар, хөл, ам	211	14.3	81	5.8	81	6.0	0	0.0
B34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй		0.0		0.0	87	6.5	87	
Эритема	2	0.1	0	0.0	118	8.8	118	
Хачигт риккетсиоз	0	0.0	1	0.1		0.0	-1	-100.0
Хачигаар дамжих вирүст энцеофалит		0.0		0.0		0.0	0	
Ковид-19						0.0	0	
Бусад	0	0.0	0	0.0	90	6.7	90	
Хумхаа	1	0.1	0	0.0		0.0	0	
Тэмбүү	104	7.1	125	8.9	112	8.3	-13	-10.4
Төрөлхийн тэмбүү	0	0.0	0	0.0	0	0.0	0	

Заг хүйтэн	32	2.2	37	2.6	49	3.6	12	32.4
Сүрьеэ	109	7.4	106	7.6	106	7.9	0	0.0
Мөөгөнцөр	14	0.9	18	1.3	19	1.4	1	5.6
Трихомониаз	86	5.8	88	6.3	66	4.9	-22	-25.0
ХДХВ/ДОХ	0	0.0	0	0.0	0	0.0	0	

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж

тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

I-XIII/2025


Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 10 сард 597.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 109.2 (22.4%) тэрбум төгрөгөөр, сангийн зарлага 242.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 30.4 (14.3%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, тэрбум төгрөг

Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого 485.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 87.9 (22.1%) тэрбум төгрөгөөр өсч, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 9.8 (23.0%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний

даатгалын сангийн орлого 7.5 (23.4%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 4.0 (25.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, тэрбум төгрөг



Сангуудын зарлага өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 26.2 (13.5%), тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 2.4 (22.4%) тэрбумаар, ҮОМШӨ-ний даатгалын

сангийн зарлага 57.5 (4.3%) сая төгрөгөөр буурсан, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 1.8 (31.7%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн сангаас 2025 оны эхний 10 сард 107.0 мянган хүнд 86.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 8.3 (7.3%) мянган хүнээр буурсан бол олгосон тэтгэмж 2.9 (3.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 5.

Нийгмийн халамжийн үйлчилгээний төрлөөр, сая төгрөг

Үйлчилгээний төрөл	2024 I-X	2025 I-X	Зөрүү	Хувь
Нийгмийн халамжын тэтгэвэрт	8 423.8	9 588.5	1 164.7	13.8
Нийгмийн халамжын тэтгэмж	59 790.1	61 044.6	1 254.5	2.1
Асаргааны тэтгэмж	7 636.6	8 522.5	885.9	11.6
Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох	3228	3031.4	-196.6	-6.1
Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, тэтгэмж	923.9	848.8	-75.1	-8.1
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	3 459.9	3 280.1	-179.8	-5.2
Нийт	83 462.3	86 315.9	2 853.6	3.4

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2025 оны эхний 8 сард 104610 хүн хамрагдаж 7.8 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 9328 (8.1%) буурч, олгосон мөнгөн тэтгэвэр 2.9 (3.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжэнд 71081 хүн хамрагдаж 55.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 377 (1.3%) хүнээр, олгосон тэтгэмж 1.3 (2.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн

даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



ГЭМТ ХЭРЭГ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 3362 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 611(22.2%) хэргээр өссөн байна.

2025 оны эхний 10 сард 3362 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 611 (22.2%) хэргээр өссөн үзүүлэлтэй байна.

Гэмт хэргийн улмаас 545 хүн гэмтэж осолдон, 60 хүн нас барж, төр ард иргэдэд 53.5 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 18.6 тэрбум (34.8%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 45.5 хувийг залилан, 14.0 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 13.1 хувийг хулгайн, 1.1 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 4.5 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын

журмын эсрэг, 1.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.8 хувийг дээрэм, 1.0 хувийг хүчин, 0.11 хувийг хүн амь, 17.4 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 10 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Тоо	Хувь
Дүүргийн дүн	2 148	2 751	3 362	611	22.2
Хүний амь	2	3	4	1	33.3
Хүчин	11	38	35	-3	-7.9
Дээрэм	20	34	60	26	76.5
Хулгай	421	488	439	-49	-10.0
Залилан	1 038	1 161	1 531	370	31.9
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	511	510	472	-38	-7.5
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	46	122	151	29	23.8
Бусдыг амиа хорлоход хүргэх	11	14	46	32	3.3**
Бусдын хөрөнгө ашиглах	35	32	38	6	18.8
Бусад гэмт хэрэг	53	349	586	237	67.9

ХҮСНЭГТ 7.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өөрчлөлт	
	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	21 934	26 174	28 888	2 714	10.4
Багануур	169	278	332	54	19.4
Багахангай	18	17	25	8	47.1
Баянгол	3 872	4 152	4 499	347	8.4
Баянзүрх	5 140	7 660	7 192	-468	-6.1
Налайх	281	279	278	-1	-0.4
Сонгинохайрхан	3 123	3 159	4 100	941	29.8
Сүхбаатар	3 712	3 975	4 282	307	7.7
Хан-Уул	3 264	3 903	4 818	915	23.4
Чингэлтэй	2 355	2 751	3 362	611	22.2

2025 оны эхний 10 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2986 (88.8%) нь хөнгөн хэрэг, 376 (11.2%) нь хүнд хэрэг байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

I-XII/2025


Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

Дүүргийн төсвийн нийт орлого 224.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 25.0 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 10 сарын байдлаар 224.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 25.0 (10.0%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 98.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 1.0 хувийг татварын бус орлого, 0.5 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна.

2025 оны эхний 10 сарын байдлаар дүүргийн татварын орлого 221.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 20.9 (8.6%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 2.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3.6 (61.9%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

ЗУРАГ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 10 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	249 450.2	224 474.9	-24 975.3	-10.0%
A. Урсгал орлого	247 942.6	223 433.0	-24 509.7	-9.9%
1. Татварын орлого	242 135.5	221 221.6	-20 913.9	-8.6%
1.1. Орлогын албан татвар	209 964.9	190 428.0	-19 536.9	-9.3%
1.2. Өмчийн татвар	6 310.6	5 144.6	-1 166.0	-18.5%
1.3. Бусад татвар (төлбөр хураамж)	25 860.1	25 649.0	-211.0	-0.8%
2. Татварын бус орлого	5 807.1	2 211.4	-3 595.8	-61.9%
Б. Хөрөнгийн орлого	-	-	-	-
В. Тусламжийн орлого	1 507.6	1 041.9	-465.6	-30.9%

*Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2025 оны эхний 10 сарын байдлаар 215.3 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 22.2 (9.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт зарлагын 6.1

хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 21.6 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал 59.7 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

ЗУРАГ 8.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг



ХҮСНЭГТ 9.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 оны эхний 10 сард, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	234 489.7	215 267.3	-22 222.4	-9.4%
A. Урсгал зарлага	213 290.0	189 525.3	-23 764.6	-11.2%
1. Бараа, үйлчилгээний зардал	73 495.1	61 022.3	-12 472.8	-17.0%
1.1. Цалин, хөлс	16 178.4	13 106.1	-3 072.3	-19.0%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	2 136.9	1 519.2	-617.7	-28.9%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	55 179.9	46 397.0	-8 782.8	-15.9%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	139 794.9	128 503.0	-11 291.8	-8.1%
3.1. Татаас	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	139 794.9	128 503.0	-11 291.8	-8.1%
Б. Хөрөнгийн зардал	24 199.7	25 742.0	1 542.2	6.4%
Хөрөнгө оруулалт	24 199.7	25 742.0	1 542.2	6.4%

ЗУРАГ 9.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ


I-XII/2025

Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2025 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.9 хувь, өмнөх сараас 0.7 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар



Хэрэглээний үнийн индекс 2025 оны 10 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 6.9 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 10.0 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 6.2 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 4.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 6.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 7.8 хувь, тээвэр бүлгийн үнэ 1.8 хувь, холбооны

хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний үнэ 2.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 5.0 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 13.6 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 8.9 хувиар, даатгал санхүүгийн үйлчилгээ 6.1 хувиар, бусад бараа үйлчилгээний үнэ 8.7 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 10.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2024 X 2023 X	2025 X 2024 X	2025 X 2024 XII	2025 X 2025 IX
Ерөнхий индекс	7.0	9.9	6.9	0.7
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	6.2	12.6	10.0	0.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	5.6	7.0	6.2	0.6
Хувцас, бөс бараа, гутал	12.0	6.1	4.3	0.6
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	9.3	22.8	6.5	1.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	7.7	8.2	7.8	0.4
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.9	6.4	6.2	0.4
Тээвэр	-1.0	4.7	1.8	0.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.5	2.4	2.4	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	7.2	5.4	5.0	0.0
Боловсролын үйлчилгээ	34.1	13.6	13.6	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	11.6	9.8	8.9	0.2
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.7	6.1	6.1	0.0
Бусад бараа, үйлчилгээ	14.9	8.8	8.7	1.3

ЗУРАГ 11.

ГУРИЛ, ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн X сард, төгрөг




ЗУРАГ 12.

ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн X сард, төгрөг




ЗУРАГ 13.

ТӨМС, ЛУУВАНГИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн X сард, төгрөг



ЗУРАГ 14.

ТАРАГ, СУҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, ЖИЛ БҮРИЙН Х САРД, ТӨГРӨГ



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

- I_{ct}^L – t тайлант үеийн Ласдейресийн үнийн индекс
- t – Тайлант үе
- 0 – суурь үе
- P_t^i – i барааны тайлант үеийн үнэ
- P_0^i – i барааны тайлант үеийн үнэ
- q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигла



НИЙТИЙН АЖ АХУЙ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2908.5 мян.м² зам талбай цэвэрлэж, 21709.3 тн хог тээвэрлэжээ.

ХҮСНЭГТ 11.

ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2025 оны 10 дугаар сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 X	2024 X	2025 X	2024/2025	
					Дүн	Хувь
Цэвэрлэсэн талбай	мян.м ²	2 908.5	2 908.5	2 908.5	-	-
Тээвэрлэсэн хог	Тн	17 220.8	25 384.1	21 709.3	-3 674.8	-14.5
Орон сууц	Тн	-	-	-	-	-
Гэр хороолол	тн	15 611.0	21 162.3	16 409.2	-4 753.1	-22.5
Албан газар	тн	1 609.9	4 221.8	5 300.1	1 078.3	25.5
Зам талбай	Тн	-	-	-	-	-
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	1 019.2	2 330.2	2 158.2	-172.0	-7.4
Зам талбай	сая.төг	213.2	1 142.2	1 326.9	184.7	16.2
Гэр хороолол	сая.төг	730.6	990.4	767.9	-222.5	-22.5
Орон сууц	сая.төг	50.2	160.1	205.9	45.8	28.6
Албан газар	сая.төг	25.2	37.5	42.1	4.6	12.3

*Эх үүсвэр: Найши ХХК, ТҮК

2025 оны 10 дугаар сард тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 3674.8 тн (14%) өссөн байна. Ажил үйлчилгээний орлого 2 158.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 172.0 (7.0%) сая төгрөгөөр буурчээ. Орлогын эх үүсвэрийг

ангилбал 35.6 хувийг гэр хороолол, 61.5 хувийг зам талбай, 9.5 хувийг орон сууцны цэвэрлэгээ үйлчилгээнээс олсон орлого тус тус эзэлж байна.



ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 47967 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 892(1.5%) зөрчилөөр өссөн байна.

Чингэлтэй дүүргийн Тээврийн Цагдаагийн албаны хэлтсийн алба хаагчид 2025 оны эхний 10 сард гудамж замд хийсэн хяналт

шалгалтаар 60490 зөрчил илрүүлж, 2326 хүнийг торгож, эрх хасах, 901 хүнийг торгох, шийтгэл оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 12.

ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

Торгууль	2023 I-X	2024 I-X	2025 I-X
Торгуулсан хүний тоо	85 770	59 598	60 490
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	2 554.9	948.5	1 712.7

ХҮСНЭГТ 13.

ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр	2023 I-X	2024 I-X	2025 I-X
НИЙТ ЗӨРЧИЛ	73 365	59 598	60 490
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	2 618	1 236	992
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	804	523	1 038
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	6 148	4 008	4 880
Хамгаалах бүс хэрэглээгүй	4 539	9 686	7 836
Хориглосон нөхцөлөөр зогссон	22 874	9 078	5 090
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	15	28	22
Эгнээ байраа буруу эзэлсэн	2 707	1 390	2 473
Бусад зөрчил	33 660	33 649	38 159

*Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс



ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 10 дүгээр сарын 15

2025 оны эхний 10 сард иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг 81175 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3180 (4.1%) хүнээр өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 14.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	2024 I-X	2025 I-X	2024/2025	
	Дүнгээр		Дүн	Хувь
Нийт	77 995	81 175	3 180	4.1
Шинэ төрсөн	2 461	2 016	- 445	- 18.1
Гэрлэлт	652	506	- 146	- 22.4
Гэр бүл цуцлалт	351	276	- 75	- 21.4
Хүүхэд үрчлэлт	44	33	- 11	- 25.0
Эцэг тогтоосон	106	85	- 21	- 19.8
Овог, нэр өөрчлөх	135	103	- 32	- 23.7
Шилжин ирсэн	5 304	5 942	638	12.0
Лавлагаа	44 536	47 598	3 062	6.9
Иргэний үнэмлэх олголт:	12 203	12 308	105	0.9
16 нас хүрч шинээр авсан	2 782	3 034	252	9.1
Дахин олголт	9 421	9 274	- 147	- 1.6

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Онцгой байдал:

2025 оны эхний 10 сард 480 аюулт үзэгдэл, ослын дуудлага ирсэнээс худал дуудлага 26 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 31.6 хувиар буурчээ.

Ахуйн 349 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 34.2 хувиар нэмэгджээ. Гал түймрийн аюулаас 1173 хүн, 132.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна.

ХҮСНЭГТ 15. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 10 сард

Үзүүлэлтүүд	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Дуудлагын тоо	332	345	480	135	39.1
Худал дуудлага	2	38	26	-12	-31.6
Гал түймрийн тохиолдлын тоо	285	260	349	89	34.2
Унтраасан гал түймрийн тоо	188	199	342	143	71.9
Ашигласан ус, тонн	825	897.8	1 481.6	584	65.0
Ашигласан шатахуун /дизель/, литр	2 791.3	6 815.7	8 846.9	2 031	29.8
Ашигласан хөөс, литр	-	150	2 458	2 308	15.4*
Зарцуулсан хөрөнгө, сая.төг	20.0	26.5	31.7	5.2	19.6
Аварсан хүний тоо	219	350	1 173	823	2.4*
Учирсан хохирол, сая.төг	5 505.0	39 740.5	132 398.2	92 657.7	2.3*

¹-дахин их * Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ

ЗУРАГ 16. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 10 сард



ОНЦГОЙ БАЙДАЛ, 2025 оны эхний 10 сард

2025 оны эхний 10 сард нийт 480 гал түймэр, гамшиг ослын дуудлага бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 135(39.1%)-аар өсчээ.



Дуудлагын тоо
480



Ашигласан шатахуун
8 846.9



Гал түймэр
349



Зарцуулсан мөнгө /сая.төг/
31.7



Аварсан хүний тоо
1 173



Худал дуудлага
26

Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ:

2025 оны эхний 10 сард 7 төрлийн үйлчилгээг нийт 39849 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 696.0 сая төгрөгийн хураамж авсан байна.

ХҮСНЭГТ 16. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, ТӨРЛӨӨР

Үйлчилгээний төрөл	2025 I-X сар					
	Эд хөрөнгийн бүртгэл		Газар		Газраас бусад	
	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)
Нийт	27 188	485 968	4 875	30 523	7 786	179 555
Анхны бүртгэл	2 248	3 736	488	1 280	614	1 185
Өмчлөх эрх шилжих гэрээ	5 927	109 144	1 003	19 396	1 653	30 180
Барьцааны гэрээ	15 386	359 311	2 579	8 206	4 319	144 553
Бусад гэрээ	503	630	45	185	198	390
Бүртгэлд өөрчлөлт оруулах	1 234	10 800	464	1 012	504	2 804
Урьдчилсан тэмдэглэл	523	924	48	149	154	160
Лавлагаа хуулбар	1 367	1 423	248	295	344	283

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Улаан загалмай: 2025 оны эхний 10 сард 24539 хүнд 43610 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь хамрагдсан хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 3858 (18.7%) хүнээр зарцуулсан зардал 3460 (8.6%) мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 17. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР ЭХНИЙ 10 САРД

Үзүүлэлт	2024 I-X			2025 I-X		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Дүн	324	20 681	40 150	513	24 539	43 610
Халамж үйлчилгээ	22	820	23 400	53	1 071	15 400
Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа	81	1 854	5 960	82	2 643	5 000
Анхны тусламжийн сургалт	50	1 825	1 500	33	1 000	2 300
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	22	705	420	49	1 248	1 900
Гамшгийн тусламж	2	10	350	4	26	940
Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа	31	6 264	3 040	64	6 120	6 240
Донорын өдөрлөг, сурталчилгаа	20	3 500	530	52	2 594	600
Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа	23	1 102	2 450	41	2 556	6 030
Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа	73	4 601	2 500	135	7 281	5 200

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Халамжийн чиглэлээр сургалт, сурталчилгааг 82 удаа зохион байгуулж 2643 иргэн, анхны тусламжийн сургалт 33 удаа зохион байгуулж 1000 иргэн, хүүхэд залуучуудын хөдөлгөөний

чиглэлээр сургалтыг 41 удаа зохион байгуулж 2556 иргэн, хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7-н зарчим, төр, улаан загалмайн хамтын ажиллагааны сурталчилгааг 135 удаа зохион байгуулж 7281 иргэнийг тус тус хамруулсан байна.

Захиргааны мэдээлэл: Иргэдээс 2025 оны эхний 10 сард 3430 өргөдөл, гомдол ирснээс 2603 (75.9%)-ыг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 827 (24.1%) нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна.

ХҮСНЭГТ 18.

ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2025 оны эхний 10 сард

Ангилал	2025 I-X	Үүнээс:	
		Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэж хариу өгсөн
Нийт	3 430	827	2 603
Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	31	6	25
Нутгийн захиргааны байгууллагууд	1 899	458	1 441
1800-1200 дугаарын оператор	185	51	134
11-11 төвөөс ирсэн	1 266	298	968
Гар утасны аппликэйшнээр ирсэн	-	-	-
Мессеж	-	-	-
E-Service	36	9	27
Facebook	-	-	-
Дижитал сити	5	2	3
Хороо бүртгэсэн	4	1	3
НМХГ тусгай дугаар	4	2	2

* Эх үүсвэр: Дүүргийн өргөдөл, гомдлын мэдээ

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	Г. Пүрэвсүрэн
I	Эрүүл мэнд	Б.Мишээлт
II	Нийгмийн даатгал, халамж	Б.Мишээлт
III	Гэмт хэрэг	Г. Пүрэвсүрэн
IV	Төсөв	Г. Пүрэвсүрэн
V	Хэрэглээний үнэ	Л. Шинэтуяа
VI	Нийтийн аж ахуй	Л. Шинэтуяа
VII	Дүүргийн аюулгүй байдал	Г. Пүрэвсүрэн
VIII	Төрийн үйлчилгээ	Б. Мишээлт Л. Шинэтуяа



Авлигатай тэмцэх газар

Хэрэв танд:

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу:

Үүнд:

22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;

22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;

22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хахууль авах/;

22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/;

22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/;

22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;

22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;


22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;

22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/;

22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;

22.13 дугаар зүйл /Хахууль авах/;

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХУСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/



Авлигыг мэдээлэх утас

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ Хүлээн авах суваг

— Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн
Утсаар: (976)-110 /Ярианы төлбөргүй/
дугаараар
Факс: (976)-11-311919
Цахим шуудангийн хаяг: contact@iaac.mn
Шуудан холбоогоор: Улаанбаатар хот 14250,
Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн
удамж 41 хаягаар
Веб сайт: iaac.mn

Авлигын эсрэг



Үгүй гэж хэлээд өөрчилъе! 110

